



**БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/38

Хөхбүрд

Г Сумын хэмжээнд өдөр тутмын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Г

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах дадлага сургуулилт хийх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн сумын хэмжээнд өдөр тутмын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Сумын хэмжээнд өдөр тутмын бэлэн байдал зарласантай холбогдуулан гамшгийн үед ажиллах арга техник, орон нутгийн онцлогт тохирсон дадлага, сургуулилтыг үе шаттай зохион байгуулж, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагажуулах, шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувцас хэрэгслээр ханган анхан шатны хэрэглэгдэхүүний нөөцийг бүрдүүлж ажиллахыг Шуурхай штабын гишүүд болон сумын Орлогч дарга болон Шуурхай штабын дарга (Д.Гансүх)-д даалгасугай.

3.Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеэр ажлаас чөлөө авах, ажлын цагаар ажлын байрыг орхигдуулахгүй нэгдсэн дадлага сургуулилт, гамшгийн үеийн голомтын бүсээс зөвшөөрөлгүй гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг албан байгууллагын дарга, эрхлэгч нар болон нийт албан хаагчдад анхааруулсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Орлогч дарга, Шуурхай штабын дарга (Д.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Т.БЯМБАДОРЖ



642401283



تاریخ: ۱۳۹۰/۰۵/۰۵
 شماره: ۶۰۰
 موضوع: ...

این سند در تاریخ ۱۳۹۰/۰۵/۰۵
 در تهران صادر شده است.

این سند در تاریخ ۱۳۹۰/۰۵/۰۵
 در تهران صادر شده است.

این سند در تاریخ ۱۳۹۰/۰۵/۰۵
 در تهران صادر شده است.

این سند در تاریخ ۱۳۹۰/۰۵/۰۵
 در تهران صادر شده است.